

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.002>

Улс төр-дипломатын аргаар үндэсний аюулгүй байдалд тулгарч буй аюул, эрсдэлийг бууруулах боломж, арга зам

П.Батжаргал

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн Гадаад орчны судалгааны төв

ABSTRACT

Within the framework of safeguarding its security through political and diplomatic means, Mongolia sets the objective of upholding national interests in its foreign policy, fostering friendly cooperation with all the countries of the world, and, to the extent of its capacity, making active contributions to the efforts of the international community to strength peace and security.

Steadfastly adhering to a peace-oriented foreign policy and actively supporting and participating in the endeavors of the international community aimed at consolidating global peace and security are integral components of Mongolia's policy and practice of ensuring national security through political and diplomatic means.

Keywords: *National security, policy, diplomacy, international relations.*

УДИРТГАЛ

Олон улсын харилцаанд гарч буй хурдацтай өөрчлөлт, аюулгүй байдлын шинэ сорилтууд хөгжиж буй улс орнуудын аюулгүй байдлын асуудлыг улам бүр эмзэг байдалд хүргэж байна. Тухайлбал: Орос-Украины дайн, Израил-ХАМАС-ын сөргөлдөөн, Сирийн дэглэмийн уналт болон Грийнланд, Канадыг АНУ-д нэгтгэх Д.Трампын мэдэгдэл зэрэг үйл явдал хөгжиж буй жижиг улс, орнуудын аюулгүй байдал дэлхийн геополитикийг тодорхойлогч томоохон гүрнүүдийн ашиг сонирхлоос ихээхэн хамааралтай хэвээр байгааг нотлон харуулж байна.

Аюулгүй байдлын онолоор улс орон өөрийн эрх ашгийг хангах аюулгүй байдлын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замтай байхыг онцолдог. Энэхүү өгүүлэлд улс төр-дипломатын арга замаар улс орны өмнө тулгарч буй аюул, эрсдэлийг бууруулах боломж, арга замыг тодорхойлохыг зорьсон болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Улс төр-дипломатын аргаар аюулгүй байдалд тулгарч буй аюул, эрсдэлийг бууруулах гэдэг нь Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрхзүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах замаар улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд учирч болзошгүй аливаа аюул, эрсдэлийг урьдчилан харж, сөрөг нөлөөг бууруулах зорилгоор явуулж буй бодлого,

үйл ажиллагааны цогц арга хэмжээ хэмээн ойлгож болно.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 1.3-т “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрхзүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн”, 1.7-д “Дэлхий, бүс нутгийн нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдал орохоос сэрэмжилнэ” гэжээ.

Улс төр-дипломатын дараах арга замаар үндэсний аюулгүй байдалд тулгарах аюул, эрсдэлийг бууруулах боломжтой юм. Үүнд:

- Олон улсын хамтын ажиллагааны механизмууд, түүний дотор НҮБ-ыг чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулах;
- Дэлхий нийтийн болон Монгол Улсын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхолд нийцсэн асуудлаар санал, санаачилга гаргах;
- НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг оролцуулах;
- Хөрш хоёр улстайгаа эн тэнцүү харилцах;
- “Туравдагч хөрш”-ийн бодлого баримтлах.

Энхтайванч бодлогын арга хэрэгсэл буюу онолын хувьд либерализмын арга хэрэгслийг ашиглахыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулсан. Иймээс дипломат ажиллагаа бол олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүндэтгэх, харилцан буулт хийх, зөвшилцөх замаар бусад үндэстэнтэй харилцах арга юм. Энэ утгаараа дипломат ажиллагаа бол гадаад бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга зам болно. Улс төр-дипломатын аргыг ашиглахдаа гадаад бодлогын дүн шинжилгээнд суурилсан хувилбарыг сонгох шаардлагатай байна.

УИХ-аар 2000 онд баталсан Дипломат албаны тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 3.1-д “Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрхзүйн хэм хэмжээний хүрээнд Монгол Улсын төрийн гадаад бодлогын зорилт, чиг үүргийг нэгдмэл, залгамж чанарыг хадгалах замаар хэрэгжүүлэх мэргэшсэн үйл ажиллагааг дипломат алба гэнэ” хэмээн тодорхойлж, 5.1.7-д “Монгол Улсын нэгдмэл, залгамж чанартай гадаад бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын төр, засгийн албан ёсны байр суурийг илэрхийлэх” хэмээн ГХЯ-ны чиг үүргийг тус тус тодорхойлсон¹. Хуулийн дагуу Монгол Улсын нэгдмэл, залгамж чанартай гадаад бодлогыг хэрэгжүүлэх ажлыг ГХЯ зохион байгуулж, Монгол Улсын төр, засгийн албан ёсны байр суурийг илэрхийлдэг боловч улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах, аливаа эрсдэл сорилтыг бууруулах үйл ажиллагаа дан ганц ГХЯ-ны хариуцах ажил биш юм. Улс төр-дипломатын ажиллагааг тухайн улс орны үндэсний онцлог, шийдвэр гаргахад нөлөөтэй хувь хүн (төрийн өндөр албан тушаалтнууд)-ий талаарх нарийн судалгаан дээр үндэслэж явуулдаг тул аюулгүй байдлын судалгааны байгууллагуудын оролцоо чухал ач холбогдолтой.

Харилцан хамааралтай, даяаршсан орчинд жижиг улсын гадаад бодлого илүү прагматик байх ёстой бөгөөд Монгол Улсын гадаад бодлого энэ хэлбэрээр

¹ Монгол Улсын Дипломат албаны тухай хууль. УБ., 2000

явж байгаа нь улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангахад суурь болж буй юм. Гадаад бодлогод нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалах нь Монгол Улсын өмнө тулгарч болзошгүй аливаа аюул, эрсдэл, сорилтыг улс төр-дипломатын аргаар бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд нэн чухал болно.

Монгол Улсын гадаад бодлого нэгдмэл байх ёстой. Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах гэдэг нь төрийн үндсэн гурван институт болох Ерөнхийлөгчийн институт, хууль тогтоох дээд байгууллага, гүйцэтгэх засаглал гадаад харилцааны асуудлаар нэгдсэн бодлого явуулж, гадаад ертөнцтэй “нэг цонх”-оор харьцах өөрөөр хэлбэл, гадаад бодлогын асуудлаар нэг дуу хоолойтой байна гэсэн үг юм.

Монгол Улс улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах хүрээнд гадаад бодлогодоо үндэсний ашиг сонирхлыг дээдлэх, дэлхийн бүх улстай найрсаг хамтын ажиллагаа хөгжүүлэх болон энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс гаргаж байгаа хүчин чармайлтад өөрийн боломжийн хэрээр идэвхтэй хувь нэмэр оруулах зорилт тавьдаг.

Иймээс Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийг бууруулах улс-төр дипломатын арга замын нэг хэлбэр (Foreign policy instruments, tools) нь олон улсын хамтын ажиллагааны механизмууд, түүний дотор НҮБ-ыг чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулах явдал юм. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцох нь үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны нэг хэсэг юм.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд олон улсын аюулгүй байдлын орчинд үүссэн томоохон зөрчил сөргөлдөөнийг шийдвэрлэхэд НҮБ-ын байр суурь сул байгааг шүүмжлэх хандлага байгаа ч дэлхийн олон улс орныг хамарсан ийм хэмжээний хамтын ажиллагааны өөр механизм өнөөг хүртэл бий болоогүй байна.

НҮБ-д чиглэсэн бодлогоор аюулгүй байдалд тулгарч буй аюул, эрсдэлийг бууруулах гэдгийг олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, дэлхий нийтийн болон Монгол Улсын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхолд нийцсэн асуудлаар санал, санаачилга гаргах замаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа баталгаажуулж, үндэсний аюулгүй байдалд тулгарч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор явуулж буй бодлого, үйл ажиллагаа хосолсон цогц арга хэмжээ хэмээн тодорхойлж болно.

Энэ бодлогын хүрээнд “НҮБ-ын хүмүүнлэгийн тусламж, логиستيкийн бүс нутгийн төв”-ийг Монгол Улсад байгуулах санал, санаачилга гаргаж болох юм.

Учир нь дэлхий нийтийг хамарсан цар тахал болон газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшиг илүү давтамжтай тохиолдох болсон энэ цаг үед Монгол Улсад “НҮБ-ын хүмүүнлэгийн тусламж, логиستيкийн бүс нутгийн төв”-ийг байгуулах нь газар зүйн байрлалын хувьд оновчтой юм. Манай улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлого, Зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийн огтлолцолд оршдог газар зүйн онцлог байрлал зэрэг нь энэ санал, санаачилгыг дэвшүүлэхэд давуу байдал болох юм.

Энэ санаачилга нь улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах арга замыг хэрэгжүүлэх бодит үр дүн болохоос гадна Монгол Улсын эдийн засгийн хөгжилд түлхэц болох ач холбогдолтой гэж үзнэ. Монгол Улсад “НҮБ-ын хүмүүнлэгийн тусламж, логистикийн бүс нутгийн төв”-ийг байгуулснаар юуны түрүүнд НҮБ болон бүс нутгийн хамтын ажиллагааны бусад механизмуудаас манай улсыг чиглэсэн үйл ажиллагаа идэвхэжнэ. Монгол Улсын дэд бүтцийн хөгжил, үндэсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, стандартад нааштайгаар нөлөөлөхөөс гадна хэдэн зуун ажлын байр шинээр нэмэгдэх сайн талтай юм.

Бидэнд хамгийн ойрын жишээ бол Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцож, үүрэг гүйцэтгэж байсан Сьерра Леон улсын Тусгай шүүхийн үйл ажиллагаа юм. 2000 оны зургаадугаар сард Сьерра Леоны Ерөнхийлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу мөн оны наймдугаар сард НҮБ-ын Аюулгүйн зөвлөл 1315 дугаар шийдвэрээр цэргийн гэмт хэрэгтнүүдийг шүүх Тусгай шүүх байгуулсан байдаг. Энэ байгууллага 2000-2013 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулах хугацаанд НҮБ-ын олон зуун алба хаагч, энхийг сахиулагчид (түүний дотор Монгол Улсын ЗХ-ний 10 ээлжийн 2500 ЦАХ) үүрэг гүйцэтгэсэн. Мөн Сьерра Леон улсын олон зуун иргэн Тусгай шүүхийн үйлчилгээний салбарт ажиллаж ажлын байраар хангагдаж байв. НҮБ-ын харьяа тус байгууллагын Сьерра Леон улсад оруулсан хөрөнгө оруулалт үлэмж их юм.

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах, дуу хоолойгоо хүргэхэд олон талт хамтын ажиллагаа чухал үүрэгтэй юм. Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсноос хойш тус байгууллагын үндсэн зорилго, зарчмуудыг тууштай дэмжиж, өөрийн хувь нэмрээ оруулж, идэвхтэй хамтран ажиллаж ирсэн.

Үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах чиглэлд хийсэн Монгол Улсын анхны томоохон зоримог алхам нь Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1992 оны есдүгээр сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 45 дугаар чуулганы индэр дээрээс Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэхдээ: “Монгол Улс зэвсэг хураах хийгээд бүс нутаг, дэлхий дахинд итгэлцлийг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах үүднээс өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлан тунхаглаж байна. Үүнийгээ цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно”² хэмээн зарлаж, улмаар цөмийн зэвсэгтэй таван улсаар хүлээн зөвшөөрүүлсэн нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах бодлогын үр дүнтэй хэрэгжилт болсон юм.

Манай улс олон улсын энх тайван, аюулгүй байдал, зэвсэг хураах, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, ардчилал, засаглалыг бэхжүүлэх, эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн олон асуудлаар Ерөнхий Ассамблейн нийт 90 гаруй тогтоол

² Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд хэлсэн үг. Нью-Йорк.: 1992.09.25;

санаачлан хэлэлцүүлж батлуулсан. Өдгөө “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай”, “Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай”, “Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүргийн тухай”, “Бичиг үсгийн боловсролын тухай”, “Ардчиллын боловсролын тухай” гэсэн Ерөнхий Ассамблейн 5 тогтоолыг санаачлан батлуулаад байгаа билээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй (Single State Nuclear Weapon free zone) хэмээн зарласан явдлыг олон улсын хамтын нийгэмлэг сайшаан хүлээн авч, дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд үүний илрэл нь “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолыг анх 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаар батлуулсан явдал юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1998 оноос хойш хоёр жил тутам баталж байгаа “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолд “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах, улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх” тухайд Монгол Улстай хамтран ажиллахыг НҮБ-ын гишүүн улс, орнуудад уриалсан байдаг нь үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах бодлого тасралтгүй хэрэгжиж байгаагийн баталгаа гэж болно.

Цөмийн зэвсэг бүхий таван гүрэнтэй явуулсан яриа хэлэлцээний дүнд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжих зорилгоор эдгээр таван улс 2000 онд “Хамтарсан мэдэгдэл”, 2012 онд “Хамтарсан тунхаглал” гаргасан.

НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг илгээж олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах нь нэгэнт манай улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болжээ. Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцсоноор Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгасан аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болж, олон улсад Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх, нэр хүндийг өргөхөд жинтэй хувь нэмэр оруулж байна. Монгол Улсын Засгийн газар НҮБ-тай байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, 2002 оноос өнөөг хүртэл Монгол Улсын Зэвсэгт хүчнээс энхийг дэмжих ажиллагаанд давхардсан тоогоор нийт 20 мянга гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн. 2025 оны тавдугаар сарын байдлаар Өмнөд Судан, Абией муж, Баруун Сахар, Йемен зэрэг дэлхийн халуун цэгүүдэд явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчнээс нийт 880 орчим цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 онд ИБУИНХУ-ын Глазгоу хотноо болсон “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт”-д оролцохдоо дэлхий нийтийн өмнө тулгараад буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахын тулд 2030 он гэхэд Монгол Улсад тэрбумаар тоологдох мод тарих санаачилга гаргасныг дэлхийн

улс орнууд талархан хүлээн авч, хамтран ажиллахаа илэрхийлээд байна. Энэ нь Монгол Улсын олон тулгуурт идэвхтэй гадаад бодлогын нэг хэлбэр юм.

НҮБ-д чиглэсэн бодлогоор аюулгүй байдлаа хангах гэж Америк, Орос, Хятадын ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн, НҮБ тэргүүтэй олон улсын хамтын нийгэмлэгт тулгуурласан олон туйлт гадаад бодлогын хэрэгжилт гэж үзэж болно.

Монгол Улс цаашид зэвсэг хураах, энхийг сахиулах, хүмүүнлэгийн болон гамшгийн эсрэг зэрэг НҮБ-ын бүх гишүүн орнууд санал нэгдэж чадахуйц нийт хүн төрөлхтний нийтлэг эрх ашигт нийцсэн асуудлыг шийдвэрлэхэд олон улсын тавцанд идэвхтэй оролцох нь үндэсний аюулгүй байдлаа хангах гол үндэслэл болно гэж үзэж байна.

Дээр дурдсанчлан Монгол Улсын нутаг дэвсгэр дээр НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын ар тал хангалт, тээвэр логистикийн төвийг байгуулах, зэвсэгт хүчний бүрэлдэхүүнээс НҮБ-ын энхийг сахиулах түргэн байрлах хүчинд томилгоожуулах, энхийг сахиулах сургалтын төв бааз байгуулах, олон улсын төрийн болон ТББ-ууд орж ирж ажиллах нөхцөл бүрдүүлэх, өрнө дорныг холбосон хийн хоолой, төмөр зам, хурдны замын коридор, сэргээгдэх эрчим хүчний төв байгуулах зэргээр дэлхийн хамтын нийгэмлэгийн эрх ашгийг аль болох их хэмжээгээр Монголд оруулж ирэх нь энэхүү бодлогын мөн чанар мөн³.

НҮБ-д чиглэсэн бодлогын алсын хараа нь их гүрнүүдийн нийтлэг ашиг сонирхлыг нь Монголд оруулж эвлэлдүүлэх, тэдний хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх явдал юм. Их гүрнүүд зэвсэг хураах, хүмүүнлэг, гамшиг, энхийг сахиулах асуудал дээр ямар ч тохиолдолд санал нэгдэж чаддаг нь энэхүү бодлого хэрэгжих боломжтойг харуулж байна.

НҮБ бол дэлхийн хамгийн том улс төрийн байгууллага бөгөөд түүний онцлог нь их гүрнүүд өөрсдийн ашиг сонирхлыг тусгасан тогтоол, шийдвэрүүдийг Аюулгүйн зөвлөлөөр дамжуулан батлуулж, хэрэгжүүлдэг явдал юм. НҮБ нь аливаа хямралыг зохицуулахад шаардлагатай хүч хөрөнгө, санхүүгийн нөөц багатай тул ихэвчлэн улс төрийн ерөнхий шийдвэрийг нь гаргаж, бодит асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг их гүрнүүдийн эвсэл, холбоодод даатгах хандлагатай байдаг.

НҮБ-ын ЕНБД-ыг их гүрнүүдээс томилдоггүй бөгөөд тэдний зөвшилцлийн үндсэн дээр тив тивийн дундаж хөгжилтэй орнуудаас ээлжлэн сонгодог уламжлалтай. Харин Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг дэлхийн санхүүгийн гол байгууллагуудын удирдлагыг Америк, Франц зэрэг их гүрнүүдэд дархлан хуваарилдаг нь тэдгээрийн ноёрхлыг хадгалах нэг хэлбэр болдог.

НҮБ-ын жилийн төсвийн 25-аас доошгүй хувийг АНУ дангаараасанхүүжүүлдэг явдал тус байгууллагын дотоод удирдлагад Америкийн нөлөөг нэмэгдүүлдэг. Үүний үр дүнд НҮБ-ын ихэнх байгууллагын хүний нөөц, санхүү, захиргааны гол албан тушаалуудыг америкауд хашиж, төрөлжсөн агентлагуудын удирдлагыг томилоход ч АНУ чухал байр суурь эзэлж ирсэн. Иймд Ази тивд ардчилал, эрх чөлөөний арал гэгдэж буй Монгол Улс НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын аль нэг удирдах

³ Эрдэнэцогт Д. “НҮБ-д чиглэсэн бодлогоор аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийг бууруулах арга зам” судалгааны ажл. -УБ., 2023.

албан тушаалд АНУ-ын дэмжлэгтэйгээр томилогдох бодит боломжтой юм⁴.

НҮБ-ын өндөр албан тушаалд бодлогоор томилогдсон хүн нь олон улсын тавцанд улс орныхоо эрх ашгийг хамгаалах, нэр хүндийг өргөх чухал үүрэгтэй байдаг. Тухайлбал: үндсэн ажлынхаа хажуугаар албан тушаал, алдар цол, нэр хүнд, хувийн харилцаа холбоогоо ашиглан эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд өргөх, маргаантай болон тулгамдсан асуудлуудыг үндэстэндээ ашигтайгаар шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, улс орныхоо язгуур эрх ашгийг олон улсын хэмжээнд хамгаалах, тусгаар тогтнол, аюулгүй байдлын бас нэгэн баталгаа болж байдгаараа чухал ач холбогдолтой.

Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад тулгарч буй эрсдэл, сорилтыг бууруулах бас нэгэн арга замыг “гуравдагч хөрш”-ийн бодлого хэмээн бид хардаг.

Монгол Улс хөрш хоёр улстайгаа эн тэнцүү харилцах талаар ГБҮБ болон ҮАБҮБ-даа тодорхой зааж өгсөн. Өөрөөр хэлбэл: хөрш хоёр улсын нөлөөний тэнцвэрийг хангахаа албан ёсоор тунхаглахын зэрэгцээ гадаад тэнцвэрийг “гуравдагч хөрш”-өөр төлөөлүүлсэн юм. Хоёр хөршийн харилцаанд аль нэг нь давамгайлах нөхцөлд “гуравдагч хөрш” мөн тэнцвэрийг хадгална хэмээн ойлгож болно.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогоор аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах гэдэг нь Монгол Улсын ҮАБҮБ-ын 3.1.1.5-д заасанчлан өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, хүчний тэнцвэрийг хангах замаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа улам бүр баталгаажуулах арга зам юм.

Монгол Улс «гуравдагч хөрш»-ийн бодлогынхоо хүрээнд өндөр хөгжилтэй, ардчилсан улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хангах гол арга зам гэж тодорхойлсон. Энэ ч зорилгоор Япон, Энэтхэг, Америк, Турк, Герман, Өмнөд Солонгос, Канад, Австрали⁵ зэрэг бүс нутгийн өндөр хөгжилтэй, ардчилсан улс орнуудтай түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлж байна. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын гол агуулга нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс төдийгүй дэлхийн нөлөө бүхий бусад улс гүрнүүдийн геополитик, гео-эдийн засаг, стратегийн сонирхол, нөлөө, хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино⁶. Өөрөөр хэлбэл: Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй, ардчилсан орнуудтай хөгжүүлэх харилцаа нь манай “гуравдагч хөрш”-ийн бодлогын суурь болно хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын бодлогын баримт бичигт тусгаснаар “гуравдагч хөрш”-ийн бодлого нь улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн чиглэлд өндөр хөгжилтэй улсуудтай харилцахад чиглэх бол Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай

⁴ Мөн тэнд

⁵ Гуравдагч хөршийн бодлого. ГХЯ. (2023.03.14) <https://mfa.gov.mn/mongolian-foreign-policy/dипломат-харилцаа/third-neighbors>

⁶ ГХЯ. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, -УБ., 2006. т.11

батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлд хамтран ажиллах бодлого мөн баримталж байна.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого цаашид хэрхэн чанаржиж явагдах ёстой вэ? Энэ талаар зарим судлаач “Манай “гуравдагч хөрш”-ийн бодлого хоёр хөршөөсөө бусад улстай хийх хоёр талт харилцаагаар хязгаарлагдахад хүрч, шинэ зүйл ажиглагдахгүй байна” гэсэн бол гуравдагч хөрш улсын дипломатч асан энэхүү бодлого бүдгэрч байгаад шүүмжлэлтэй хандсан нь ч байна⁷.

Монголчууд хоёр хөрш орноос гадна “гуравдагч хөрш” орнууд гэдэгт ямар улсыг хамруулж, хэрхэн үнэлж тодорхойлж байгааг доорх судалгаагаар илэрхийлж байна⁸.



Хоёр хөрш болон “гуравдагч хөрш” орнуудын талаарх иргэдийн үнэлгээ

Дээрх судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын 46 хувь нь БНХАУ-ын талаар эерэг, 38 хувь сөрөг сэтгэгдэлтэй, үлдсэн 16 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариулт өгчээ. Харин бидний “гуравдагч хөрш” гэдэг Америк, Япон, Өмнөд Солонгосоос гадна Казахстан, Туркийн талаар судалгаанд оролцсон иргэдийн эерэг сэтгэгдэл давамгайлж байгаа нь эдгээр оронтой харилцаа илүү ойр байгааг харуулахын зэрэгцээ зөвхөн “өндөр хөгжилтэй” орнуудыг “гуравдагч хөрш” хэмээн нэрлэх нь учир дутагдалтай болохыг илэрхийлж байна. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Габит Койшибаев ССХ-ийн “Элчин сайдын цаг” дугуй ширээний ярилцлагад 2024 оны аравдугаар сарын 4-ний өдөр оролцоходоо “Казахстан нь Монгол Улсын хамгийн ойрын “гуравдагч хөрш” юм шүү” гэж хэлснийг бид анхаарах нь зүйтэй юм. Учир нь “гуравдагч хөрш”-үүдээ олон улсын харилцаанд эзлэх байр суурь, эдийн засгийн хөгжлөөр эрэмбэлэх нь зохимжгүй. Тэгвэл Монгол Улстай олон жилийн уламжлалт найрсаг харилцаатайгаас гадна

⁷ Такэнори Шимизү (2023.03.25) <https://www.youtube.com/watch?v=UQaUJRYis2U>

⁸ Стратеги судалгааны хүрээлэн. “Нийгмийн барометр судалгаа”. Уб.2023.

⁹ Стратеги судалгааны хүрээлэн. “Элчин сайдын цаг уулзалтын тэмдэглэл”. -УБ.. 2024.

хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай ч мөн адил маш ойрын харилцаатай БНАСАУ “өндөр хөгжилтэй”, “ардчилсан” гэсэн категорид тохирохгүй учир манай “гуравдагч хөрш” болохгүй юу?, ер нь “өндөр хөгжилтэй”, “ардчилсан” гэж ялгаварлах нь зөв үү?, хоёр хөршөөс бусад дипломат харилцаатай улс бүр манай “гуравдагч хөрш” байж болохгүй юу? гэсэн аргууд байна.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод АНУ-тай харилцах харилцаа чухал ач холбогдолтой гэдгийг өнөөгийн нөхцөлд хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй билээ. АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратегид холбоотны харилцааг бэхжүүлэх зорилтын хүрээнд аюулгүй байдлын гэрээтэй таван улсаас гадна бүс нутгийн дараах орнуудтай харилцаа холбоогоо бэхжүүлнэ гэж заасан есөн орны жагсаалтад Монгол Улсыг оруулсан байдаг. Харин манай хоёр хөрш орны зүгээс АНУ-тай сөргөлдсөн бодлого явуулж байгаа нь Монгол Улсын хувьд харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд сорилт болж байна. Энэ нь Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод хоёр хөрш ОХУ, БНХАУ таагүй хандах гол шалтгаан болдог.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн бид гадаад бодлогынхоо эн тэргүүний зорилттой зөрчилдсөн бодлого явуулаад байна уу, манай “гуравдагч хөрш”-ийн бодлого аюулгүй байдлаа хангах бодлого уу эсвэл аюулгүй байдлаа хангах бодлогын хэрэгсэл үү гэсэн аргууд мөн үүснэ.

Монгол Улс ГБҮБ-даа “... ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийн харгалзах...” хэмээн заасан. Өөрөөр хэлбэл: хоёр хөрштэйгөө найрсаг харилцаатай байх нь манай гадаад харилцааны тэргүүлэх зорилт юм.

Зарим судлаач “гуравдагч хөрш”-ийн бодлогыг Монгол Улсын аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх нэгэн чухал арга хэрэгсэл гэж үздэг. Тухайлбал: судлаач, доктор (Ph.D) Г.Базарваань “Бид арга хэрэгслээ бодлого хэмээн томъёолсноор хоёр хөрш улстай найрсаг харилцаатай байх гадаад бодлогын тэргүүлэх зорилт болон тэргүүлэх чиглэлийн хөршүүдээ эргэлзүүлж, гадаад бодлогын арга хэрэгсэл /”гуравдагч хөрш”-ийн бодлого/-ээ тэдний эсрэг бодлого хэмээн ойлгоход хүргэсэн... “Гуравдагч хөрш”-ийн бодлого бол үзэл санаа, бие даасан бодлого ч бус. Энэ бол түүхэн хугацаанд бүрэлдэж бий болсон манай гадаад бодлогын хэрэгсэл. Тодруулбал: манай улсын энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах нэг хэрэгсэл болно”¹⁰ гэсэн нь сонирхолтой аргумент юм.

Тэгвэл Монгол Улсын ҮАБҮБ-д “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” хэмээн

¹⁰ Базарваань Г. “Гадаад бодлогын арга, хэрэгслээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах онол, практикийн үндэслэл”. УБ., 2024

зааснаар “гуравдагч хөрш”-ийн бодлогыг үндэсний аюулгүй байдлаа хангах өргөн хүрээний бодлого болохыг тодорхойлсон гэж болно. Үүнээс гадна “гуравдагч хөрш”-ийн бодлого нь хоёр хөршийн хоорондын харилцаанаас аль болох хамааралгүй байх гадаад нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой тул энэ бодлого нь өөрөө мөн чанарын хувьд зөөлөн тэнцвэржүүлэх бодлого байх ёстой болж байна.

Монгол Улс зөөлөн тэнцвэржүүлэх арга хэрэглэхдээ олон улсын харилцааны тогтсон онол, баримтлалд тулгуурлавал илүү үр дүнтэй болно. Олон улсын харилцааны реалист онолд аливаа улсын үндэсний эрх ашиг, гадаад бодлогын уялдааг авч үзсэн байдаг явдал “гуравдагч хөрш”-ийн бодлогын зорилгыг тайлбарлахад ашиглаж болохоор байна. Өөрөөр хэлбэл: хоёр хөршийн ашиг сонирхлын тэнцвэрийг хадгалах Монгол Улсын гадаад бодлогын зорилго тогтмол төдийгүй реалист шаардлагатай хэмээн үзнэ. Гэхдээ тэнцвэрийг хадгалахаар бидний сонгосон улс ардчилал, либерал онолын үзэл баримтлалтай буюу арга зам маань либерал онолд тулгуурладаг.

Бид үндэсний амин чухал эрх ашгаа хангахын тулд хоёр хөрш болон “гуравдагч хөрш” орнуудтай харилцах тэнцвэрийг хадгалах нь урт хугацааны стратегийн ач холбогдолтой юм. Энэ хүрээнд ЗХА-ийн бүс нутгийн интеграцид идэвхтэй оролцох нь Монгол Улс “гуравдагч хөрш”-ийн бодлогыг шинэ агуулга, хэлбэрээр хэрэгжүүлэх чухал боломж юм. Тиймээс одоогийн түнш Япон, Өмнөд Солонгостой хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийн зэрэгцээ Вьетнам, Энэтхэг, Филиппин, Индонез зэрэг улстай эдийн засгийн хамтын ажиллагааны суурийг тавих нь Монгол Улсын хувьд алсдаа эдийн засгийн хэт хараат хамаарлыг бууруулах, тэнцвэрийг хангах, “гуравдагч хөрш”-ийн бодлогыг эдийн засгийн шинэ агуулгаар баяжуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад стратегийн чухал алхам болно.

Монгол Улсын аюулгүй байдлын стратегийн чухал бүс нутаг болох энэхүү орон зайд хүн ам, эдийн засаг, хөгжлийн хүчирхэг төвлөрөл бий болж байгаагийн зэрэгцээ их гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн улам бүр ширүүсэж, стратегийн орчин асар хурдацтай өөрчлөгдөж байна. Энэ бүс нутагт манай улстай найрсаг болон түншийн харилцаатай “гуравдагч хөрш” орнуудын томоохон төлөөлөл олон бий. Тэдгээр улстай тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа болгон ардчиллыг бэхжүүлэх, ардчиллын үнэт зүйлст тулгуурласан харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал юм. Иймээс энэ чиглэлээр идэвхтэй, үр дүнтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын нэг чухал зорилт нь тус улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрхзүйн зарчим, хэм хэмжээний хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, гадаад бодлогын тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлд “гуравдагч хөрш”-тэй нягт хамтран ажиллаж, Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрхзүйгээр баталгаажуулах хэрэгт дэмжлэг авах явдалд оршино.¹¹

¹¹ Уламбаяр Д. “Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого ба, цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын харилцан хамаарал”-Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгохоор зарласны 25 жил: Үр дүн, цаашид тавих зорилт сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. -УБ., 2017

ДҮГНЭЛТ

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь мөнхийн хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай харилцах харилцаа мөн боловч тэдний дан болон хавсарсан нөлөө, дарамтад орж, гадна орчноос тусгаарлагдах нь манай улсын тусгаар тогтнол, бие даасан байдалд учирч болзошгүй хамгийн ойрын буюу хамгийн том эрсдэл юм. Иймд олон улсын харилцааны шилжилтийн гэх энэ цаг үед Монгол Улс хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай, найдвартай түнш байхын зэрэгцээ “гуравдагч хөрш”-ийн бодлогынхоо хүрээнд тэнцвэржүүлэх бодлогоо тууштай хэрэгжүүлэх нь улам бүр чухал ач холбогдолтой болж байна.

Их гүрнүүдийн ил, далд зөрчил мөргөлдөөн хэрхэн улс орнуудын хувь заяанд ноцтой аюул, эрсдэл учруулж болохыг өнөөдрийн Украины дайн, Ойрх Дорнодын бүс нутгийн хямрал тод жишээ болгон харуулж байна. Иймд аливаа гуравдагч талтай хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын харилцаанд тухайн асуудал бүрд баримтлах байр суурьт онцгойлон анхаарч, хөрш орнуудтай илт сөргөлдсөн бодлого явуулахгүй тэнцвэртэй байдлыг хангах нь илүү оновчтой юм.

Улам бүр хурцдаж буй геополитикийн өрсөлдөөн нь олон улсын аюулгүй байдлын орчин, дунд болон жижиг улсуудын аюулгүй байдлаа хангах бодлого, стратегийг тодорхойлоход гол хүчин зүйл болж байна. Ийм нөхцөлд ялангуяа жижиг улс, их гүрнүүдийн ашиг сонирхол, бодлого, стратегитай харшлахгүй байдлаар өөрийн бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нь үр дүнтэй байх чухал нөхцөл юм. Тухайлбал: Монгол Улсын нэг улсын цөмийн зэвсэггүй статус болон НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг гадаад бодлогын санаачилгууд нь хоёр хөрш болон АНУ-ын ашиг сонирхолтой зөрчилдөхгүй тул тэдгээрийн дэмжлэгийг авч, хэрэгжилтийн хувьд үр дүнтэй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Болд Р. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах арга зүйн зарим асуудалд. -//Стратегийн судалгаа. -УБ., 2025.
2. Уламбаяр Д., Түвшинтөгс А. «Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол Улс» -УБ., 2011;
3. Стратеги судалгааны хүрээлэн. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал”. УБ., 2022.
4. Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль. -//Төрийн мэдээлэл. УБ., 2002. №3;
5. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. -//“Төрийн мэдээлэл”. №36. УБ., 2010
6. Баяр С. “Монгол Улсын ҮАБ-ын үзэл баримтлалын талаарх санал, дүгнэлт, зөвлөмж”. Стратеги судлал. УБ., 2022
7. Базарваань Г. “Гадаад бодлогын арга, хэрэгслээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах онол, практикийн үндэслэл”. УБ., 2024
8. Соёлгэрэл Н. Аюулгүй байдал судлал дахь үндэсний аюулгүй байдлаа хангах бодлого ба Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Стратеги судлал. -УБ., 2020.

9. Монгол Улсын Дипломат албаны тухай хууль. УБ., 2000;
10. Стратеги судалгааны хүрээлэн. “Элчин сайдын цаг, уулзалтын тэмдэглэл”. -УБ.2024;
11. Уламбаяр Д. “Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого ба, цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын харилцан хамаарал”- Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгохоор зарласны 25 жил: Үр дүн, цаашид тавих зорилт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. -УБ., 2017
12. Уламбаяр Д. “Монгол Улс байнга төвийг үл сахих нь” .УБ., 2016
13. Мөнх-Очир Д. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах үндэслэл, үзэл санаа”. Стратегийн судалгаа. №96(II/2025) Улаанбаатар,2025
14. ГХЯ.Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, -УБ., 2006
15. Гуравдагч хөршийн бодлого. ГХЯ. (2023.03.14) <https://mfa.gov.mn/mongolian-foreign-policy/дипломат-харилцаа/third-neighbors>
16. Эрдэнэцогт Д. “НҮБ-д чиглэсэн бодлогоор аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийг бууруулах арга зам” судалгааны ажил. -УБ., 2023.
17. Батжаргал П. “Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийн онол, практикийн шинжилгээ”.УБ.2025.